



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.com

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Баярмаа
Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЦАГААННУУР
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ К.ГҮЛЖАН ТАНАА

2026.02.05 № 35
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол

833805000285

асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>153,492,081.42</u> | <u>88,693,837.56</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 96,247,989.57 | 24,442,322.67 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 96,247,989.57 | 24,442,322.67 |
| 3121 | Төгрөг | 96,247,989.57 | 24,442,322.67 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 96,247,989.57 | 24,442,322.67 |
| 33 | АВЛАГА | 2,634,000.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 2,634,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 54,610,091.85 | 64,251,514.89 |
| 351 | Түүхий эд материал | 12,511,218.89 | 12,511,218.89 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,481,618.89 | 12,481,618.89 |
| 35130 | Эм боох материал | 29,600.00 | 29,600.00 |
| 354 | Хангамжийн материал | 42,098,872.96 | 51,740,296.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,968,011.07 | 3,689,111.07 |
| 35420 | Аж ахуйн материал | 31,917,983.00 | 37,836,933.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 2,214,850.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,122,418.89 | 1,582,593.90 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,090,460.00 | 6,416,808.03 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>2,714,917,595.10</u> | <u>2,642,413,547.16</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,714,917,595.10 | 2,642,413,547.16 |
| 392 | Биет хөрөнгө | 2,674,540,165.82 | 2,602,391,927.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,685,205,148.00 | 2,685,205,148.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (257,259,715.59) | (315,166,053.15) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 99,431,250.00 | 99,431,250.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (27,343,593.75) | (37,286,718.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 173,924,155.90 | 203,188,155.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (98,574,945.82) | (122,593,676.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,619,659.48 | 111,919,659.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (52,778,354.09) | (61,622,399.53) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,166,666.54) | (4,166,666.50) |
| 39217 | Ном | 33,483,228.23 | 33,483,228.23 |
| 393 | Биет бус хөрөнгө | 40,377,429.28 | 40,021,619.56 |
| 39301 | Програм хангамж | 1,973,239.00 | 1,973,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (905,809.72) | (1,261,619.44) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,310,000.00 | 39,310,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>2,868,409,676.52</u> | <u>2,731,107,384.72</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>6,887,592.00</u> | <u>12,855,294.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 6,887,592.00 | 12,855,294.00 |
| 413 | Өглөг | 6,887,592.00 | 12,855,294.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,253,592.00 | 2,215,250.00 |
| 4136 | Бусад өглөг | 2,634,000.00 | 10,640,044.00 |

| | | | |
|------------|-----------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,634,000.00 | 10,640,044.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,861,522,084.52 | 2,718,252,090.72 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,861,522,084.52 | 2,718,252,090.72 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 272,770,780.68 | 272,770,780.68 |
| 51101 | Өмч: - төрийн | 272,770,780.68 | 272,770,780.68 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,090,867,575.84 | 1,947,597,582.04 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,090,867,575.84 | 2,091,966,875.84 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (144,369,293.80) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 497,883,728.00 | 497,883,728.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,868,409,676.52 | 2,731,107,384.72 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,541,299,367.78 | 1,577,389,848.03 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 139,286,967.78 | 9,632,848.03 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 139,286,967.78 | 9,632,848.03 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 3,423,300.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,423,300.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 132,159,467.78 | 9,000,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 3,704,200.00 | 632,848.03 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО | 1,402,012,400.00 | 1,567,757,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,243,114,400.00 | 1,422,126,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,243,114,400.00 | 1,422,126,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 158,898,000.00 | 145,630,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 158,898,000.00 | 145,630,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,421,384,135.27 | 1,721,759,141.83 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,421,384,135.27 | 1,721,759,141.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,385,140,185.27 | 1,667,474,679.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 962,811,236.00 | 1,183,945,804.00 |
| 210101 | Үндсэн цалин | 584,402,802.00 | 696,798,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 340,718,854.00 | 428,197,468.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 11,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 37,689,580.00 | 47,685,036.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 126,279,100.00 | 145,527,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,869,700.00 | 98,958,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,102,300.00 | 11,641,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,051,200.00 | 5,821,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,051,200.00 | 5,821,200.00 |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|------------------------------|--------------------------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,204,700.00 | 23,284,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 160,326,231.00 | 175,333,308.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,887,071.00 | 6,787,630.00 |
| 210302 | Түлш, халаалт | 150,321,000.00 | 160,322,470.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,118,160.00 | 8,223,208.00 |
| 2105 | Нормативт зардал | 15,038,197.00 | 15,039,519.99 |
| 210502 | Хоол, хүнс | 15,038,197.00 | 15,039,519.99 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 101,000.00 | 1,557,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 101,000.00 | 1,557,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,599,632.43 | 19,322,249.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,423,300.00 | 6,371,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,176,332.43 | 12,950,849.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,984,788.84 | 126,749,397.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,084,518.00 | 18,048,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,493,600.00 | 6,633,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 85,406,670.84 | 102,068,047.94 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,243,950.00 | 54,284,462.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,243,950.00 | 54,284,462.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,243,950.00 | 54,284,462.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>119,915,232.51</u> | <u>(144,369,293.80)</u> |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>119,915,232.51</u> | <u>(144,369,293.80)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---------------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,402,801,700.00</u> | <u>1,567,757,000.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 789,300.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 789,300.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 789,300.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 789,300.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | <u>1,402,012,400.00</u> | <u>1,567,757,000.00</u> |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,243,114,400.00 | 1,384,370,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,243,114,400.00 | 1,384,370,100.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 158,898,000.00 | 183,386,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 158,898,000.00 | 183,386,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,336,187,019.43</u> | <u>1,618,998,666.90</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>1,336,187,019.43</u> | <u>1,618,998,666.90</u> |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | <u>1,299,943,069.43</u> | <u>1,569,374,566.90</u> |

| | | | |
|-------------|----------------------------------------------------------------------|-----------------------------|-------------------------------|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 962,811,236.00 | 1,183,945,804.00 |
| 210101 | Үндсэн цалин | 584,402,802.00 | 696,798,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 340,718,854.00 | 428,197,468.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 11,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 37,689,580.00 | 47,685,036.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 126,279,100.00 | 145,527,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,869,700.00 | 98,958,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,102,300.00 | 11,641,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,051,200.00 | 5,821,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,051,200.00 | 5,821,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,204,700.00 | 23,284,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 157,398,000.00 | 180,386,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,077,000.00 | 17,066,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 150,321,000.00 | 160,320,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 16,065,053.00 | 14,499,663.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,065,053.00 | 14,499,663.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,500,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 3,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,965,632.43 | 16,628,549.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 789,300.00 | 1,534,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,176,332.43 | 15,093,849.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,924,048.00 | 25,386,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,893,948.00 | 19,566,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,030,100.00 | 5,820,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,243,950.00 | 49,624,100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,243,950.00 | 49,624,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 36,243,950.00 | 49,624,100.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>66,614,680.57</u> | <u>(51,241,666.90)</u> |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 20,354,000.00 | 20,564,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,354,000.00 | 20,564,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 20,354,000.00 | 20,564,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,354,000.00 | 20,564,000.00 |

| | | | |
|----|---------------------------------------------------------------------------|------------------------|------------------------|
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>(20,354,000.00)</u> | <u>(20,564,000.00)</u> |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 46,260,680.57 | (71,805,666.90) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 49,987,309.00 | 96,247,989.57 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 96,247,989.57 | 24,442,322.67 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-----------------------------------------------|------------------------------------------|-----------------------------|----------------------|--------------------------------------------------|
| C01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 1,970,952,343.33 | 2,741,606,852.01 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 1,970,952,343.33 | 2,741,606,852.01 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 119,915,232.51 | 119,915,232.51 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 2,090,867,575.84 | 2,861,522,084.52 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 2,090,867,575.84 | 2,861,522,084.52 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,099,300.00 | 1,099,300.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 2,091,966,875.84 | 2,862,621,384.52 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -144,369,293.80 | -144,369,293.80 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 272,770,780.68 | 497,883,728.00 | 1,947,597,582.04 | 2,718,252,090.72 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------------|-----------------------------------------------------|--------------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 96,247,989.57 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,662,635,600.00 | 1,639,562,666.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,662,634,700.00 | 1,639,562,666.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,613,010,600.00 | 1,589,938,566.90 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,192,808,100.00 | 1,183,945,804.00 |

| | | | |
|---------------|----------------------------------------------------------------------|------------------|------------------|
| 210101 | Үндсэн цалин | 750,983,400.00 | 696,798,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 408,439,200.00 | 428,197,468.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 11,265,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,385,500.00 | 47,685,036.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 149,101,000.00 | 145,527,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 101,388,600.00 | 98,958,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,928,100.00 | 11,641,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,964,100.00 | 5,821,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,964,100.00 | 5,821,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,856,100.00 | 23,284,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 180,386,000.00 | 180,386,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,066,000.00 | 17,066,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 160,320,900.00 | 160,320,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 19,820,200.00 | 14,499,663.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 19,820,200.00 | 14,499,663.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,742,200.00 | 17,748,549.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,534,700.00 | 1,534,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,207,500.00 | 16,213,849.90 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,153,100.00 | 44,830,650.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,112,500.00 | 39,010,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,040,600.00 | 5,820,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,624,100.00 | 49,624,100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 49,624,100.00 | 49,624,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,624,100.00 | 49,624,100.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,662,635,600.00 | 1,567,757,000.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,477,714,000.00 | 1,382,835,400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,477,714,000.00 | 1,382,835,400.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 183,386,900.00 | 183,386,900.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 183,386,900.00 | 183,386,900.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,534,700.00 | 1,534,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,534,700.00 | 1,534,700.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 96,247,989.57 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 24,442,322.67 |

| | | | |
|-----------|---------------------------------------------------------------|--------------|--------------|
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 40.00 | 44.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22.00 | 23.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17.00 | 19.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 1.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 40.00 | 44.00 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 22.00 | 23.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 1.00 | 2.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 15.00 | 16.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | - | 1.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дугаар албан бичгээр 01 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цагааннуур тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,421.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан 19.1 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг мэдээлээгүй, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 91.9 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” , 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн байршуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх;

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагааннуур тосгоны ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн ба давтан шалгаж үзэхэд хэрэгжүүлсэн байна..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|----------|------------------------|-----|---------|-----|-------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 1 | 0.0 | 1 | 0.0 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын бүртгэл, тооллоготой холбоотой асуудлыг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 212.8 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөвт санхүүжүүлэх эх үүсвэрийг 94,9 сая төгрөгөөр дутуу, зардалд санхүүжүүлэх эх үүсвэрийг 39.3 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

Санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллаганы санхүүжилт /улсын төсөв/, урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөв/-ийн орлогыг 37.8 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан алдааг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

5.2 Албан шаардлага

Бичигдээгүй.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийсэн боловч бараа материалын тооллогын бүртгэлийн баримтжуулалт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2- “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллогын бүртгэлийг бүрэн хөтөлж баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-----------|-----------------------------------|----------|--------------------------|----------|------------|-----------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөвт санхүүжүүлэх эх үүсвэрийг 94,9 сая төгрөгөөр дутуу, зардалд санхүүжүүлэх эх үүсвэрийг 39.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан. | 2 | 134.169.4 | 1 | 94.878.6 | 1 | 39.290.8 | 2 | 134.169.4 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайлан, | 2 | 78,581.6 | | | 2 | 78,581.6 | 2 | 78,581.6 | | | | |

